



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/30/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.01.25 № 56
танай _____ ны № _____ т

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд байгууллагын харилцах дансаар 479,859,970.00 /дөрвөн зуун далан есөн сая найман зуун тавин есөн мянга есөн зуун дал/ төгрөгийн цалингийн зардал гарсан, цалингийн цэс анхан шатны баримт зөрүүтэй, аудитын явцад ХХОАТ-ын 8,109,845.79 /найман сая нэг зуун есөн мянга найман зуун дөчин таван төгрөг далан ес/ мөнгөний өглөг үүссэн, НДШ-ийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн

D:/bichighereg/2022A4foot

006020247

тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,834,804.15	95,260,657.84
33	АВЛАГА	-	24,126,100.00
335	Бусад авлага	-	24,126,100.00
3351	Байгууллагаас авах авлага	-	24,126,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	72,834,804.15	71,134,557.84
351	Түүхий эд материал	182,000.00	-
35130	Эм боох материал	182,000.00	-
354	Хангамжийн материал	72,652,804.15	71,134,557.84
35410	Бичиг хэргийн материал	3,365,600.00	2,244,300.00
35420	Аж ахуйн материал	56,557,283.15	60,943,439.24
35460	Хүнсний материал	10,993,771.00	6,372,168.60
35470	Бусад хангамжийн материал	1,736,150.00	1,574,650.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,909,368,215.65	1,858,736,750.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,909,368,215.65	1,858,736,750.48
392	Биет хөрөнгө	1,862,118,846.22	1,812,429,201.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,804,978,942.60	1,804,978,942.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(98,535,222.57)	(153,046,861.29)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,000,000.00	11,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,405,555.53)	(2,138,888.85)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	99,089,030.05	107,585,770.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,432,009.92)	(43,480,549.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,505,231.96	117,049,551.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,133,905.89)	(41,571,098.73)
39217	Ном	12,052,335.52	12,052,335.52
393	Биет бус хөрөнгө	47,249,369.43	46,307,548.95
39303	Бусад биет бус хөрөнгө	48,458,010.39	48,458,010.39
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,208,640.96)	(2,150,461.44)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,982,203,019.80	1,953,997,408.32
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	11,789,613.78

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	11,789,613.78
413	Өглөг	-	11,789,613.78
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	8,109,845.79
4136	Бусад өглөг	-	3,679,767.99
41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,679,767.99
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,982,203,019.80	1,942,207,794.54
51	Засгийн газрын хувь оролцоо	1,982,203,019.80	1,942,207,794.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	269,517,804.44	269,517,804.44
51101	Өмч: - төрийн	269,517,804.44	269,517,804.44
512	Хуримтлагдсан үр дүн	699,638,898.46	659,643,673.20
51210	Өмнөх үеийн үр дүн	699,638,898.46	699,638,898.46
51220	Тайлант үеийн үр дүн	-	(39,995,225.26)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,013,046,316.90	1,013,046,316.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,982,203,019.80	1,953,997,408.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,446,389,363.72	880,328,329.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	606,069,763.72	15,764,656.09
120	Нийтлэг татварын бус орлого	589,659,863.72	15,764,656.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	589,659,863.72	15,764,656.09
	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө		13,040,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	589,659,863.72	2,724,656.09
122	Тусламжийн орлого	16,409,900.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	16,409,900.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	840,319,600.00	864,563,673.11
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	677,015,400.00	656,758,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	677,015,400.00	656,758,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	29,364,953.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,364,953.00

Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	163,304,200.00	178,440,320.11
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	870,217,272.44	913,103,605.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	870,217,272.44	913,103,605.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	783,390,869.38	862,154,624.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471,043,154.60	491,836,482.60
210101	Үндсэн цалин	317,986,681.60	310,218,245.44
210102	Нэмэгдэл	112,522,856.00	138,251,930.82
210104	Урамшуулал	40,533,617.00	43,366,306.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,838,269.74	62,812,389.45
210201	Тэтгэврийн даатгал	41,140,069.74	43,939,657.49
210202	Тэтгэмжийн даатгал	4,924,600.00	4,831,372.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,939,600.00	3,773,553.76
210204	Ажилгүйдлийн даатгал	984,900.00	976,134.69
210205	Эрүүл мэндийн даатгал	9,849,100.00	9,291,670.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	157,356,747.60	176,941,120.11
210301	Гэрэл, цахилгаан	6,302,678.00	5,423,708.00
210302	Түлш, халаалт	148,695,569.60	171,139,324.11
210303	Цэвэр, бохир ус	2,358,500.00	378,088.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,824,164.00	9,510,810.00
210401	Бичиг хэрэг	858,400.00	2,611,750.00
210402	Тээвэр, шатахуун	1,798,495.00	1,981,510.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	354,500.00	200,000.00
210404	Ном, хэвлэл		-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,503,269.00	3,287,050.00
210408	Бараа материал акталсны зардал	2,309,500.00	1,430,500.00
2105	Нормативт зардал	21,257,494.00	29,122,973.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	143,000.00	978,250.00
210502	Хоол, хүнс	20,864,494.00	28,144,723.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	9,511,350.00
210604	Урсгал засвар	-	9,511,350.00
2107	Томилолт, зочны зардал	458,000.00	281,000.00
210702	Дотоод албан томилолт	458,000.00	281,000.00

Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	4,293,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,293,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,289,039.44	77,845,298.88
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	585,500.00	400,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,703,539.44	77,445,298.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,826,403.06	50,948,980.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,910,000.00	13,967,850.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,080,000.00	13,586,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	381,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,916,403.06	36,975,727.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,916,403.06	36,975,727.73
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,403.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,403.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	576,172,091.28	(32,775,275.97)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,987,008.68	7,219,949.29
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,987,008.68	908,166.29
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	6,311,783.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,987,008.68)	(7,219,949.29)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	569,185,082.60	(39,995,225.26)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,517,804.44	1,013,046,316.90	130,453,815.86	1,413,017,937.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	269,517,804.44	1,013,046,316.90	130,453,815.86	1,413,017,937.20
C07	Тайлант үеийн үр дүн			569,185,082.60	569,185,082.60
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,517,804.44	1,013,046,316.90	699,638,898.46	1,982,203,019.80
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	269,517,804.44	1,013,046,316.90	699,638,898.46	1,982,203,019.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	269,517,804.44	1,013,046,316.90	699,638,898.46	1,982,203,019.80
D08	Тайлант үеийн үр дүн			(39,995,225.26)	(39,995,225.26)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,517,804.44	1,013,046,316.90	659,643,673.20	1,942,207,794.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	840,319,600.00	864,563,673.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	840,319,600.00	864,563,673.11
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	677,015,400.00	656,758,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	677,015,400.00	656,758,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		29,364,953.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,364,953.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	163,304,200.00	178,440,320.11
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	163,304,200.00	178,440,320.11
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	815,005,600.00	849,881,673.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	815,005,600.00	849,881,673.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	730,756,696.94	796,499,892.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471,043,154.60	479,859,970.08
210101	Үндсэн цалин	317,986,681.60	296,505,785.06
210102	Нэмэгдэл	112,522,856.00	140,190,037.95
210104	Урамшуулал	40,533,617.00	43,164,147.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,838,269.74	62,999,288.19
210201	Тэтгэврийн даатгал	41,140,069.74	44,126,556.23
210202	Тэтгэмжийн даатгал	4,924,600.00	4,831,372.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,939,600.00	3,808,833.76
210204	Ажилгүйдлийн даатгал	984,900.00	940,854.69
210205	Эрүүл мэндийн даатгал	9,849,100.00	9,291,670.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	157,356,747.60	176,941,120.11
210301	Гэрэл, цахилгаан	6,302,678.00	5,001,443.00
210302	Түлш, халаалт	148,695,569.60	171,139,324.11
210303	Цэвэр, бохир ус	2,358,500.00	800,353.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,325,795.00	4,629,760.00
210401	Бичиг хэрэг	299,600.00	465,950.00
210402	Тээвэр, шатахуун	1,798,495.00	1,615,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	354,500.00	200,000.00

Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл		168,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	1,222,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	673,200.00	957,700.00
2105	Нормативт зардал	30,158,630.00	29,234,354.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	198,000.00	471,250.00
210502	Хоол, хүнс	20,814,930.00	27,402,104.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,145,700.00	1,361,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	960,000.00	23,834,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	13,000,000.00
210604	Урсгал засвар	960,000.00	10,834,200.00
2107	Томилолт, зочны зардал	458,000.00	281,000.00
210702	Дотоод албан томилолт	458,000.00	281,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	919,000.00	6,265,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	595,000.00	6,265,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,697,100.00	12,454,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,697,100.00	10,954,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,248,903.06	53,381,780.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,332,500.00	16,400,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,502,500.00	16,018,850.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	381,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,916,403.06	36,975,727.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,916,403.06	36,975,727.73
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,403.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,403.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	25,314,000.00	14,682,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	25,314,000.00	14,682,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,314,000.00	14,682,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	25,314,000.00	14,682,000.00
222001	Тоног төхөөрөмж	3,066,000.00	6,150,500.00
223001	Бусад хөрөнгө	22,248,000.00	8,531,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(25,314,000.00)	(14,682,000.00)

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	836832700.00	798222992.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	836832700.00	798222992.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	817339400.00	781822342.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	499573800.00	479859970.08
210101	Үндсэн цалин	312262300.00	296505785.06
210102	Нэмэгдэл	142189600.00	140190037.95
210104	Урамшуулал	45121900.00	43164147.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67275000.00	62999288.19
210201	Тэтгэврийн даатгал	47167000.00	44126556.23
210202	Тэтгэмжийн даатгал	5449800.00	4831372.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	3942600.00	3808833.76
210204	Ажилгүйдлийн даатгал	974200.00	940854.69
210205	Эрүүл мэндийн даатгал	9741400.00	9291670.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	178574300.00	176941120.11
210301	Гэрэл, цахилгаан	5109000.00	5001443.00
210302	Түлш, халаалт	172536400.00	171139324.11
210303	Цэвэр, бохир ус	928900.00	800353.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4330600.00	4064810.00
210401	Бичиг хэрэг	281000.00	281000.00
210402	Тээвэр, шатахуун	1618400.00	1615110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	405,300.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	224,900.00	168,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	843,600.00	843,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	957,400.00	956,700.00
2105	Нормативт зардал	38,755,100.00	29,234,354.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	480,800.00	471,250.00
210502	Хоол, хүнс	36,913,200.00	27,402,104.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,361,100.00	1,361,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,500,000.00	14,499,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	13,000,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,499,200.00

2107	Томилолт, зочны зардал		
		281,000.00	281,000.00
210702	Дотоод албан томилолт	281,000.00	281,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
		160,200.00	53,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,200.00	53,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
		13,889,400.00	13,889,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,389,400.00	12,389,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
		19,493,300.00	16,400,650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		
		19,493,300.00	16,400,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,078,300.00	16,018,850.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	415,000.00	381,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	836,832,700.00	835,198,720.11
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
		656,758,400.00	656,758,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	656,758,400.00	656,758,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
		180,074,300.00	178,440,320.11
132001	Орон нутгийн төсвөөс	180,074,300.00	178,440,320.11
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО		
		1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		
		43.00	43.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	31.00	31.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00
620004	Гэрээт ажилтан		
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)		
		392.00	392.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД		
		392.00	392.00
630001	Төрийн өмчит ЕБС	392.00	392.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		
		57.00	57.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	43.00	43.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.00	14.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	29,359,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	29,359,550.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	29,359,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	564,950.00
210401	Бичиг хэрэг		184,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		380,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	20,800,000.00
210602	Тавилга		10,300,000.00
210604	Урсгал засвар		10,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	7,994,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,994,600.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	29,364,953.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	29,364,953.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,364,953.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хүнсний материал үлдэгдэлтэй гарч нөөц үүсгэсэн, авлага, өглөг үүсгэсэн, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй тайланд тусгасан, И-баримт түүвэрлэн үзэхэд анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ерөнхий боловсролын сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны зорилго нь “ Сурагчдад зөв хандлагыг төлөвшүүлж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлнэ.”

Энэхүү зорилгыг хангах чиглэлээр дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

1. Сурагчдын дүрэм мөрдөн хэвшүүлэх
2. Сурагчдыг хандлагын сургалтад хамруулах
3. Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх
4. Хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 877.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 9.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 143.1 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0	24126.1	24,126.10
Бараа материал	72,834.80	71,134.56	-1,700.25
Биет хөрөнгө	1,862,118.85	1,812,429.20	-49,689.64
Биет бус хөрөнгө	47,249.37	46,307.55	-941.82
Нийт хөрөнгө	1,982,203.02	1,953,997.41	-28,205.61
Өглөг	0	11789.61378	11,789.61
Хуримтлагдсан үр дүн	699,638.90	659,643.67	-39,995.23
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,982,203.02	1,953,997.41	-28,205.61

Авлага: Өмнөх оноос 24.1 сая төгрөгөөр өссөн нь Сод электроникс ХХК-иас цахим анги 11.1, Санко маркетинг ХХК-иас ухаалаг дэлгэц 13.0 төгрөгийн худалдан авалт хийж 2022 онд бараа нийлүүлэхээр гэрээг байгуулж санхүүжилтийг олгосноор авлага үүссэн байна.

Бараа материал: Бараа материалын оны эхний үлдэгдэл 72.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 71.1 сая төгрөг болж өмнөх оноос 1.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 66.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 63.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 2.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

Нийт 67.9 сая төгрөгийн бараа материал хасагдсанаас 60.2 сая төгрөг зарцуулж, аж ахуйн материалаас тушаалаар 1.4 сая төгрөгийн материал акталж, 6.3 сая төгрөгийн хүнсний материал дутагдуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосноор данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 2080.1 сая, эцсийн үлдэгдэл 2101.1 сая төгрөг болж өмнөх оноос 21.0 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 14.6 үнэ төлбөргүй / суралцагчдын эцэг эхчүүдээс/ 13.0 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 6.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тушаалаар акталж устгасан байна.

Өр төлбөр: Өглөг дансны оны эхний үлдэгдэлгүй оны эцэст 11.8 сая төгрөгийн болж өссөн нь ХХОАТ-ын 8.1, нийгмийн даатгалын шимтгэлийн 3.7 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 5 арга хэмжээнд зориулан 836.8 сая төгрөгийн төсөв баталснаас 656.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 180.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 656.8 сая төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 178.4 сая төгрөгийг санхүүжүүлж авч батлагдсан төсвөөс 1.6 сая төгрөгөөр бууруулсан, 798.2 сая төгрөгийг зарцуулж 36.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 798.2 сая төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь цалин түүнтэй адилтгах зардал 19.7, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 4.2, нормативт зардал 9.5, урсгал шилжүүлэг 3.0 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар “Тэнгэрийн хорвоончиг” ХХК-аас 15.0, “Тод алт” ХХК-аас 5.0 нийт 20.0 сая төгрөгийн хандив, аялангаа агуулгаа шинэчлэл төсөлд 8.0, БСУГ-аас ариутгал халдваргүйжүүлэлтэд 0.4, Боловсролын үнэлгээний төвөөс үнэлгээ хийх бичиг хэргийн зардалд 0.2 сая төгрөгийн орлого орж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 4.6 хувиар буюу 36.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан байна.
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсөвт зардлын 1 хувь буюу 1.6 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зарим дансны үлдэгдэл болон ажил гүйлгээ нь хангалттай зохистой баримтаар нотлогдоогүй тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөх үндэслэл болсон.

Тайлант онд байгууллагын харилцах дансаар 479.9 сая төгрөгийн цалингийн зардал гарсан, цалингийн цэс анхан шатны баримт зөрүүтэй, аудитын явцад ХХОАТ-ын 8.1 сая төгрөгийн өглөг үүссэн, НДШ-ийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.6-д “Анхан шатны баримтын

үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроосон 10, мэдээлээгүй Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр) Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр) эн мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” 6 дугаар зүйлийн 6.4.8-д “...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Тайлант онд зардлын дансанд түүвэр хийхэд нийт 1592330 төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно;”, Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын хавсралтад “5 Төлбөрийн баримт НХМаягт төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцээгүй байна.
- Тайлант онд төсвөөс 14682000 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, оны эцэст 24126100 төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна.
- Тайлант онд НДШ 3679767.99 төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, ХХАОТ-ын 8109845.79 төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд түүвэрт хамрагдаж байсан санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил ирээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цалингийн зардал, авлага өглөгийн үлдэгдлийн баталгаажуулалт зэргийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 546.3 сая төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 16.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 6.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 522.4 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

- Хөрөнгө актлах тушаалын дагуу үндсэн хөрөнгийн данснаас 6680940, бараа материалын данснаас 1430500 мянган төгрөгийн хөрөнгө актлахаар шийдвэр гарсан боловч данс бүртгэлээс хасаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйг аудитын явцад залруулга хийсэн.
- Тайлант оны ХХОАТ-ийн 8109845.79 төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-д "бүх өр төлбөр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйг аудитын явцад залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт:

Завсарын аудитаар хүнсний материалын үлдэгдэлд тооллого хийхэд 6311783 төгрөгийн хүнс дутагдуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4-т "Үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ....." заалтыг хэрэгжүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага:

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор бичиг хэргийн дансны үлдэгдэл 2244300, бусад хангамжийн материалын үлдэгдэл 1574650 нийт 3818950 төгрөгийн хөрөнгийн тооллого хийгээгүй нь өрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-д "4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;" НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.
- Тайлант онд төсвөөс 14682000 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, оны эцэст 24126100 төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.
- Тайлант онд байгууллагын харилцах дансаар 479,859,970 төгрөгийн цалингийн зардал гарсан, цалингийн цэс анхан шатны баримт нь санхүүгийн тайлантай

зөрүүтэй, аудитын явцад ХХОАТ-ын 8109845.79 төгрөгийн өглөг үүссэн, НДШ-ийн тооцоог нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүйг зөрчилд албан шаардлага өгсөн.

- Шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроосон 10, мэдээлээгүй Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр) Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр) эн мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" , 6 дугаар зүйлийн 6.4.8-д "...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйг зөрчилд албан шаардлага.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нийт 1.6 сая төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын хавсралтад "5 Төлбөрийн баримт НХМаягт төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийхдээ тухай бүр нь цахим И-баримтыг хангуулан бүртгэлд тусгаж байх.

2. Өглөгийн данстай холбоотой

3.1 Илрүүлэлт: Тайлант онд НДШ 3.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, ХХОАТ-ын 8.1 сая төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн "6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж өглөг, авлага үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	9	546.3	2	16.1	1	6.3	4	522.4	2	1.5
Дүн										